

## МХБ ЭЛЕКТРОН АРИЛЖААНЫ СИСТЕМ - АРИЛЖААНЫ ЖУРАМ

*Хавсралт 1.*

### **ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ ШИМТГЭЛ, ХУРААМЖ**

1. МХБ нь харилцагчийн тухайн өдрийн үнэт цаасны арилжаагаар хийсэн худалдах худалдан авах хэлцэл тус бүрийн дүнгээс хамааруулан шимтгэлийг дараах байдлаар тооцно. Үүнд:

1.1. Хувьцаа худалдсан ба худалдан авсан тал тус бүрээс:

1.1.1. 100 сая хүртэл төгрөгийн үнийн дүнгээс 0.4 хувийн,  
*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 02 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

1.1.2. 100 саяас 1 тэрбум хүртэл төгрөгийн үнийн дүнгээс 0.38 хувийн,  
*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 02 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

1.1.3. 1 тэрбумаас 10 тэрбум хүртэл төгрөгийн үнийн дүнгээс 0.3 хувийн,

1.1.4. 10 тэрбумаас 30 тэрбум хүртэл төгрөгийн үнийн дүнгээс 0.2 хувийн,

1.1.5. 30 тэрбумаас дээш төгрөгийн үнийн дүнгээс 0.15 хувийн,

1.2. Энэхүү хавсралтын 1.1 дэх заалт нь хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны шимтгэл тооцоход нэгэн адил хамаарна.

2. Анхдагч зах зээл дээр худалдагдсан Засгийн газар, орон нутгийн бондын арилжааны үнийн дүнгээс худалдсан талаас 0.12 хувь, худалдан авсан талаас 0.00875 хувийн,

3. Хоёрдогч зах зээл дээр Засгийн газар, орон нутгийн бонд худалдагч нь шимтгэлгүй үйлчлүүлэх ба харин худалдан авсан талаас 0.00875 хувийн,

4. Анхдагч зах зээл дээр компанийн бонд худалдсан талаас 0.1575 хувь, худалдан авсан талаас 0.0175 хувийн,

5. Хоёрдогч зах зээл дээр компанийн бонд худалдагч тал шимтгэлгүй, худалдан авагч талаас 0.0175 хувийн шимтгэлийг тус тус тооцон авна.

6. Тодорхой этгээдтэй байгуулсан гэрээнд зааснаар шимтгэл, хураамжийг тооцон авч болно.